

Д.Шүрхүү, Л.Лхамдулам, Д.Түвшин нарын бичсэн энэ ном Хятад орны түүх, улс төрийн байгуулал, эдийн засгийн шинэчлэл, шинжлэх ухаан, соёл, нийгмийн амьдрал, Монгол-Хятадын харилцааг хамран товч лавлахын хэлбэрээр бичигдсэн болно. Мөн Хятад руу зорчих хүсэлтэй уншигчдад зориулсан Бээжингийн зочид буудал, зах, дэлгүүр, үзвэрийн газрууд болон Хятад руу явах онгоц, галт тэрэгний цагийн хуваарь, гааль, Визийн талаарх мэдээлэл, Хятадад очиж суралцагсдад зориулсан зөвлөмж, хятад-монгол товч толийг багтаасан байна.

8.ОХУ-ын БН Буриад Улс. Ч.Батцэцэгийн бичсэн энэ ном хөрш Буриад улсын өнөөгийн бүх талыг хамарсан товч лавлах ном юм. Өнөөдөр угсаа гарваль нэгтэй хөрш улстайгаа ойртож, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлийн туршлагатай танилцаж, соёл, экологи, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах явдал зүй ёсны шаардлагатай болж байгаа учир энэ ном тус улсын талаар манай ажил хэрэгч хүмүүст хэрэгтэй мэдээллийг өгөх болно.

9. «The Mongolian journal of international affairs» хэмээх сэтгүүлийг англи хэл дээр 1994 оноос эхлэн жил тутам гаргаж байгаа бөгөөд үүнд Монгол орны өнөөгийн улс төр эдийн засгийн байдал, бүс нутаг, олон улсын харилцааны зарим чухал асуудлыг хөндөн бичсэн өгүүллүүд хэвлэгдэж байна.

10.»Дорно Өрнө» сэтгүүл жил тутам хоёр дугаар хэвлэгдэж Олон улсын харилцаа, Монгол Улсын гадаад бодлого, эдийн засгийн хамтын ажиллагаа, монголын түүх, эдийн засгийн шинэ судалгааг тогтмол хэвлэн нийтэлж байна.

Д.Түвшин.

МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН
ЖАГСААЛТ /1996 оны эхний хагас/

1996.01.08-10. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид БНЭУ-ын парламентын урилгаар албан ёсны айлчлал хийлээ.

1996.01.20-23. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй төлөөлөгчид Тайландын Вант улсын парламентын урилгаар Тайланд улсад албан ёсны айлчлал хийв.

1996.01.29-02.03. ШУБ-ын сайд С.Төмөр-Очир тэргүүтэй боловсролын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Дээд Боловсролын хорооны урилгаар БНХАУ-д албан ёсны айлчлал хийж,

1996-2000 онд боловсролын чиглэлээр хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурав.

1996.01.1Ү-01.24. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид «Ази Номхон далайн парламентын чуулга уулзалт» байгууллагын Ү ерөнхий хуралд оролцсоны дээр Тайландын Вант улсын парламентын урилгаар албан ёсны айлчлал хийв.

1996.01.23-26. Монгол Улсын шадар сайд Ч.Пүрэвдорж Брюссель хотноо болсон Европын холбооны Тасис Хөтөлбөр-ийг хэрэгжүүлж буй орнуудын үндэсний зохицуулагчдын ээлжит зөвлөлдөх уулзалтад оролцлоо.

1996.02.05-08. Монгол Улсын шадар сайд Ч.Пүрэвдорж Москвад болсон Монгол Оросын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын IV хуралдаанд оролцов.

1996.02.10-15. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Б.Даш-Ёндон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар ба ХБНГУ-ын Ханс Зайделийн Сангийн урилгаар Англи, Герман улсад айлчиллаа.

1996.02.07-08. Гадаад харилцааны дэд сайд Ц.Баатар «Ази тивд хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх» сэдвээр Алма Ата-д болсон Азийн орнуудын Гадаад хэргийн дэд сайд нарын зөвлөлгөөнд оролцоод Казахстан улсад ажлын айлчлал хийв.

1996.02.15. Монгол Улсын ерөнхийлөгч П.Очирбатад Данийн Вант Улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Кристофер Бо Брамсен итгэмжлэх жуух бичгээ барив.

1996.02.21-22. Япон Улсын Засгийн газар, Дэлхийн банкнаас хамтран зохион байгуулсан монголыг дэмжигчдийн тав дахь уулзалт зөвлөлгөөн Токио хотноо боллоо. Тус зөвлөлгөөнд Монгол Улсын Шадар сайд Ч. Пүрэвдорж тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Зөвлөлгөөнд 24 орон /Австрали, Бельги, Канад, БНХАУ, Дани, Финланд, Франц, ХБНГУ, Унгар, Энэтхэг, Итали, Япон, БНСУ, Голланд, Шинэ Зеланд, Португаль, ОХУ, Сингапур, Швед, Тайланд, Их Британи, АНУ/, олон улсын 9 /Европын холбоо, Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, ЮНЕСКО, НҮБ-ын

хүүхдийн сан, олон улсын санхүүгийн корпораци/ оролцож 1996 онд 212.5 сая ам.долларын зээл тусламжийг Монголд шинээр амлалаа.

1996.02.29-03.07. Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын Азийн бүсийн орнуудын зөвлөлгөөн Улаанбаатар хотод болж ОХУ, Казахстан, Кыргызстан, БНХАУ, БНАСАУ, Монгол улсын төлөөлөгчид оролцов.

1996.03.02-16. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Оман, Египет, Арабын Нэгдсэн Эмирт улс, Израйльд албан ёсны айлчлал хийлээ.

1996.03.11-16. ОХУ-ын Эрхүү мужийн захирагч Ю.А.Ножиков тэргүүтэй төлөөлөгчдийн томоохон баг монгол улсад айлчиллаа.

1996.03.27-30. Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэний урилгаар БНХАУ-д албан ёсоор айлчиллаа.

1996.03.18. Монгол Улсын Зэвсэгт хүчний 75 жилийн ойн баяр Өвөр Байгалийн цэргийн тойргийн командлагч, хурандаа генерал В.С.Третьяков тэргүүтэй ОХУ-ын зэвсэгт хүчний төлөөлөгчид, Бээжингийн цэргийн тойргийн орлогч командлагч дэслэгч генерал Гоу Бошион тэргүүтэй Хятадын Ардын Чөлөөлөх Армийн төлөөлөгчид оролцлоо.

1996.03.18. Монгол хүн сансарт ниссэний 15 жилийн ойн баярт ЗХУ-ын хошой баатар, Монгол улсын баатар, хошууч генерал В.А.Жанибеков. ЗХУ-ын хошой баатар, «Монгол анд нөхөд» нийгэмлэгийн тэргүүн, хошууч генерал В.В.Горбатко, ЗХУ-ын хошой баатар хурандаа В.А.Ляхов нар оролцов.

1996.04.02-05. Улаанбаатар хотын захирагч бөгөөд нийслэлийн засаг дарга Ц.Баасанжавын урилгаар Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лайдс хотын лорд дарга, Британийн эзэнт гүрний хоёрдугаар зэргийн одонт, нэгдсэн вант улсын урлагийн нийгэмлэгийн хүндэт гишүүн, хатагтай Пегги Уайт айлчлав.

1996.04.01. Монгол Улс Арабын Нэгдсэн Эмирт Улс /АНЭУ-тай дипломат харилцаа тогтоов. Ийнхүү АНЭУ нь Монгол улстай дипломат харилцаа тогтоосон 131 дэх улс болов. АНЭУ нь холбооны долоон жижиг вант улсаас бүрддэг. 83.6 мянган хавтгай дөрвөлжин км. нутаг, 1.6 сая гаруй хүн амтай. Нийслэл нь Абу Даби болно.

1996.04.08-11. Монгол Улсын Гадаад харилцааны сайдын урилгаар Бүгд Найрамдах Беларусь улсын Гадаад хэргийн сайд В.Л.Сенько манай улсад айлчлав.

1996.04.15-17. Монгол Улсын Гадаад харилцааны сайд С.Гомбосүрэн ОХУ-ын Гадаад хэргийн сайд Евгений Примаковын урилгаар ОХУ-д айлчлав.

1996.04.07-25. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Англи, Франц улсад айлчлав.

1996.04.14-19. Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Монголын парламентын бүлгэмийн орлогч Ж.Гомбожав тэргүүтэй төлөөлөгчид Туркийн Стамбул хотноо Олон улсын парламентын Холбооны Дэлхийн 95 дугаар бага хуралд оролцов.

1996.04.17-19. Энэтхэгийн Дели хотноо болсон Дэлхийн жижиг, дунд үйлдвэрийн ассамблейн IX чуулган Монгол Улсыг 107 дахь гишүүнээрээ элсүүлэн удирдах зөвлөлдөө сонгожээ.

1996.04.27-05.11. НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хурлын ээлжит IX чуулганд худалдаа үйлдвэрийн сайд Ц.Цогт тэргүүтэй төлөөлөгчид оролцов. МУ-ын Ерөнхий сайд П.Жасрайгаас тус чуулганд явуулсан илгээлтийг чуулганы албан ёсны баримт бичиг болгон нийт төлөөлөгчдөд тараажээ.

1996.05.06-07. Загсийн газрын өмч хувьчлалын комиссын орлогч дарга Б. Очбадрах Берлин хотноо болсон хувьчлалын зөвлөх бүлгийн VIII чуулганд Парис дахь эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын урилгаар оролцлоо.

1996.05.07-11. Гадаад харилцааны дэд сайд Ц.Баатар БНАСАУ-д ажлын айлчлал хийв.

1996. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Бүгд Найрамдах Хорват Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд итгэмжлэх жуух бичгээ барив.

1996.05.22-28. Монголын Худалдаа үйлдвэр яамны урилгаар Япон улсын Олон улсын худалдаа үйлдвэрийн яамны /ОУХҮЯ/ тусгай зөвлөх Х.Кумано тэргүүнтэй төлөөлөгчид манай оронд айлчиллаа.

1996.05.27. Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сан, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулах «Дархан-Эрдэнэтийн

авто замыг тавих төслийг санхүүжүүлэхэд зориулж зээл олгох тухай хэлэлцээрийн төслийг сангийн яамны төсвийн газрын дарга Ц.Батнасан Кувейтын сангийн төлөөлөгчдийн тэргүүн Мохомед Яссий Мохамед Авделал нар үзэглэж, протоколд гарын үсэг зурав.

1996.0529-30. Монгол Улсын Их Хурлын урилгаар ОХУ-ын Холбооны Төрийн Думын дарга Г.Н.Селезнев тэргүүтэй ОХУ-ын Төрийн Думын төлөөлөгчид манай оронд албан ёсны айлчлал хийлээ.

1996.05.29. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Бүгд Найрамдах Аргентин Улсаас Монгол Улсад суух эрхт элчин сайд Раул Алфредо Эстрада Оуэла, австралийн Холбооны Ричард Кэмпбэл нар итгэмжлэх жуух бичгээ барив.

1996.06.02. Турк Улсын Стамбул хотноо болсон НҮБ-ын Хүн амын суурьшлын асуудлаархи II бага хуралд Дэд бүтцийн хөгжлийн Дэд сайд Ц.Дамиран тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

1996.06.06-12. Франц улсад болсон «Хүний эд эрхтэн хоорондын генетик нийцэмжийн системийн олон улсын XII бага хурал»-д УИХ-ын гишүүн, доктор Ж.Батсуурь монгол хүний удамшлын тогтолцоо сэдвээр илтгэл тавилаа.

1996.06.06. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Малайз улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Датук Омардын Бин Дато Сери Абдул Вахаб итгэмжлэх жуух бичгээ барив.

1996.06.13-18. ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ОХУ-ын сонгуулийн Төв комиссын урилгаар УИХ-ын гишүүн С.Нямзагд, сонгуулийн ерөнхий хорооны гишүүн О.Баяраа Монгол Улсаас ОХУ- д суугаа элчин сайдын зөвлөх О.Энхтөр Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтын эрдэм шинжилгээний ажилтан Б.Батхишиг нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид ажиглагчаар оролцов.

Хэвлэлд бэлтгэсэн Г.Ядамсүрэн